



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/10

Арвайхээр

Буцалтгүй тусламж олгох тухай

"Төсвийн тухай" хуулийн 14.2.3, сумын Засаг даргын 2013 оны А/05 дугаар захирамжаар батлагдсан "Нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд тусламж үзүүлэх тухай" журмын 1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 11 дүгээр багийн иргэн Д.Даваадулам Улаанбаатар хотод эмчлүүлэх, 9 дүгээр багийн иргэн Х.Бямбадоржийн хүнсний хэрэгцээнд дэмжлэг үзүүлж тус бүр 50000 /тавин мянга/ төгрөгийн тусламжийг олгосугай.

2. Дээрх буцалтгүй тусламжид олгох 100000 /нэг зуун мянга/ төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгөөс гаргахыг Нягтлан бодогч /Ж.Ганзориг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

